ГОЛОМТ БАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны .11. сарын .12.өдөр **Дугаар ...00/42** **Улаанбаатар хот**

Голомт банкны Хувьцаа эзэмшигчдийн
ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 60 дугаар зүйлийн 60.1, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.3 дахь хэсэг, Голомт банкны дүрмийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2, 14.3,14.4 дэх заалт, Голомт банкны 2026 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус хурлыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2026 оны 12 дугаар сарын 23-ны өдөр зарлаж, хурлын цахим систем ашиглан эчнээ санал хураалтаар зохион байгуулсугай.
2. Голомт банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:
   2.1 Голомт Банкны Хувьцаа эзэмшигчдийн хурлын үйл ажиллагааны журмыг шинэчлэн батлах тухай.
   2.2 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох.
3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөр тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг Компанийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.4-т заасан шаардлагыг ханган хурал зарласан тухай мэдээллийг олон нийтэд мэдээлсүгэй.
5. Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг дараах байдлаар тогтоосугай. Үүнд:
   5.1 Голомт Банкны Хувьцаа эзэмшигчдийн хурлын үйл ажиллагааны журмыг шинэчилсэн найруулгыг батлах тухай мэдээлэл.
   5.2 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд нэр дэвшигчдийн танилцуулага;
6. Санал хураалтаар ирүүлсэн саналыг тоолох, үр дүнг гаргах Тооллогын комиссыг энэхүү тогтоолын Хавсралт №1-ийн дагуу баталсугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах ажлын хэсгийг энэхүү тогтоолын Хавсралт №2-ийн дагуу баталсугай.
8. Хувьцаа эзэмшигчдээс санал авах саналын хуудсыг энэхүү тогтоолын Хавсралт №3-ийн дагуу баталсугай.
9. Санал өгөх боломжтой хугацааг 2026 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн 12:00 цагаас эхлэн 12 дугаар сарын 23-ны өдрийн 12:00 цагаар тасалбар болгосугай.
10. Хурлын даргаар жижиг хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл Голомт банкны Ерөнхийлөгч Г.Ганболд-ыг томилсугай

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Ч.МӨНХЦЭЦЭГ

МОНГОЛ УЛС
ГОЛОМТ БАНК
ХК
9023051532 2075377
GOLOMT BANK